



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/23

Ховд

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол улсын Ерөнхий аудиторын 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх хэсэг, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын зарцуулалт, гүйцэтгэлд хийх аудитын тайланг” нэгдүгээр хавсралтаар баталгаажуулсугай.

2. Ажлын болон нотлох баримтын иж бүрдлийг ханган архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Д.Мөнхтулга), аудитор (Н.Ариунтуяа)-д, даалгасугай.

3. Аудитын тайланг аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлж, open.audit.mn сайтад байршуулан мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллахыг аудитын менежер (А.Цэцэгсүрэн)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ВОЛДБААТАР

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИТХ-ЫН 2025 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬ
ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС
САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД:ХОА-2025/125-ШТА-НА

Ховд хот
2025 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408 Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Мөнхтулга

Утас: 7043-2545 Цахим хаяг: : munkhtulgad@audit.gov.mn

Аудитор: Н.Ариунтуяа

Утас: 7043-2545 Цахим хаяг: ariuntuyan@audit.gov.mn

Тэргүүлэх аудитор
Х.Болдбаатар
Утас
Аудитын менежер
А.Цэцэгсүрэн
Утас:99013699
Ахлах аудитор
Д.Мөнхтулга
Утас:99031809
Аудитор
Н.Ариунтуяа
Утас:94004399
2025 оны 08 дугаар сар

Уг тайланг **YAГ-ын Веб**
сайтаас үзнэ үү.
www.audit.gov.mn

Бүлэг 1. Сумдын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд улсын төсвөөс олгох санхүүжилтийг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж хуваарилжээ.

- 1.1 Сонгуулийн хороодын зардлыг бодитой төлөвлөжээ.
1.2 Аймаг, сумдын сонгуулийн хороо нь суманд олгох санхүүжилтийг СЕХ-оос ирсэн аргачлалын дагуу хуваарилжээ.

Бүлэг 2. Сумдын ИТХ-ын нөхөн сонгуулийн зардалд 86.8 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулжээ.

- 2.1 Аймаг, сумдын сонгуулийн хороо нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.
2.2 Сонгуулийн хороод нь зардлын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнажээ.
2.3 Аймаг, сумдын сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороодын хөрөнгийн зарцуулалтад хяналт тавин ажиллажээ.

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70432545 дугаарын
утас, 70433061
дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ:

Ховд аймгийн Засаг
даргын Тамгын газар
Ховд аймаг дахь Төрийн
Аудитын газар
3 давхар

Тэргүүлэх Аудиторын тушаал
Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний Аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар

Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий Аудиторын “Аудитын сэдэв батлах тухай” 2024 оны А/107 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”-д аудит хийнэ.

Аудитын зорилт

Сумдын ИТХ-ын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан Аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох байгууллагуудад танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитын зорилтыг ханган биелүүлэхийн тулд дараах чиглэлээр аудит хийнэ.

- Сумдын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх
- Сумдын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймаг, сумдын сонгуулийн хороо, УБХ зэрэг байгууллагуудыг хамрууллаа.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль:
- Төсвийн тухай хууль:
- Монгол улсын 2024 оны төсвийн тухай хууль:
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль:
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль:
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль:
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль:
- Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам
- Батлагдсан төсөв, төсвийн хуваарь

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Ховд аймгийн хэмжээнд сумдын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль нь 3 тойрогт зохион байгуулагдсан байна.

Аймгийн сонгуулийн хороонд 7 төрийн албан хаагч 1 бичиг хэрэг, 1 нягтлан бодогч, сумдын сонгуулийн хороонд 15, харьяа хэсгийн хороонд 23, мэдээлэл технологийн багт 9, улсын бүртгэлийн 5 итгэмжлэгдсэн төлөөлөгч нийт 63 албан хаагч ажиллахаар төлөвлөжээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжих зардлыг аймгийн сонгуулийн хорооны 100160022001 тоот дансаар дамжуулан зарцуулсан байна.

Аймгийн сонгуулийн хороонд 82.2 сая төгрөг, Улсын бүртгэлийн хэлтэст 4.6 сая төгрөг, нийт 86.8 сая төгрөгийг баталжээ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу сонгууль зохион байгуулахтай холбогдсон зардлыг дараах байгууллагуудын дансаар дамжин зарцуулагдсан. Үүнд:

- Аймгийн сонгуулийн хороо
- Улсын бүртгэлийн хэлтэс

Орон нутгийн 2025 оны нөхөн сонгуульд нийт 3 хэсэгт 1,552 сонгогч сонгогчийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэнээс 791 сонгогч санал өгч 50.9 хувийн ирцтэй оролцжээ. Нийт 22 сонгогч зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналаа өгөх хуулийн хугацаанд хүсэлтээ өгч 19 иргэн саналаа өгч, 3 иргэн тухайн хаягтаа байгаагүй тул саналыг нь аваагүй байна.

СЕХ-ны 2020 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Хяналтын тооллого хийх нийтлэг журам”-ын 2.2-т заасны дагуу 100 хувь хяналтын тооллого хийсэн байна.

Бүлэг 1: Сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуульд улсын төсвөөс олгох санхүүжилтийг аргачлалын дагуу төлөвлөж хуваарилжээ

Нөхөн сонгууль зохион байгуулах сонгуулийн хороодын зардлыг бодитой төлөвлөжээ

1.1 Ховд аймгийн Сонгуулийн хороог ИТХ-ын даргын 2025 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн А/20 тоот тогтоолоор 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулжээ.

1.2 Дарви сумын ИТХ-ын 2025 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн хуралдааны 14 тоот тогтоолоор 5 хүний бүрэлдэхүүнтэй, Манхан сумын ИТХ-ын 2025 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн хуралдааны 3/10 тоот тогтоолоор 5 хүний бүрэлдэхүүнтэй, Мянгад сумын ИТХ-ыг 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдааны 3/09 тоот тогтоолоор 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус тус байгуулжээ.

1.3 Харьяалагдах нутаг дэвсгэрийн хэмжээнд нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой аймгийн сонгуулийн хороо 7, 3 сумын сонгуулийн хороонд 15, харьяа хэсгийн хороонд 23, мэдээлэл технологийн багт 9, нягтлан бодогч 1, бичиг хэргийн ажилтан 1 нийт 58 төрийн албан хаагч ажиллажээ.

1.4 Сумдын ИТХ-ын нөхөн сонгуульд нийт 1,552 сонгогч бүртгэгдсэнээс 791 сонгогч саналаа өгч 50.9 хувийн ирцтэй оролцжээ.

1.5 СЕХ-оос нутаг дэвсгэрийн хэмжээ, сонгогчийн тоо болон сумын сонгуулийн хороод, тэдгээрт ажиллах гишүүдийн тоо, хэрэгцээ шаардлагыг үндэслэн зардлыг тооцсон байна.

Аймгийн сонгуулийн хороо нь сумдад олгох санхүүжилтийг СЕХ-оос ирсэн аргачлалын дагуу хуваарилжээ

1.6 Сумдын ИТХ-ын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор СЕХ-оос аймгийн Сонгуулийн хороонд 82.2 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарилж гүйцэтгэлээр 82.1 сая төгрөгийн зардал санхүүжүүлж 0.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг төсөвт төвлөрүүлжээ.

1.7 Сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлыг сумдын сонгуулийн хороонд хуваарилахдаа хүн амын тоо, газар нутгийн хэмжээг үндэслэжээ. Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-оос ирүүлсэн зөвлөмжийн дагуу холбогдох зардлуудыг сумдын сонгуулийн хороонд хуваарилан ажиллажээ.

1.8 Аймгийн сонгуулийн хороо нь нийт төсвийн 42.1 хувь буюу 34.6 сая, сумдын сонгуулийн хороодод 57.9 хувь буюу 47.6 сая төгрөгийг хуваарилжээ.

1.9 Улсын бүртгэлийн хэлтэст УБЕГ-аас 4.6 сая төгрөгийн санхүүжилт хуваарилж гүйцэтгэлээр 4.6 сая төгрөгийг зарцуулжээ. УБХ-ээс сумдын ИТХ-ын нөхөн сонгуульд 5 төрийн албан хаагч ажиллажээ.

Бүлэг 2: Сумдын ИТХ-ын нөхөн сонгуулийн зардалд 86.8 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулжээ

Аймаг, сумдын сонгуулийн хороо нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ

2.1 Аймгийн сонгуулийн хороонд СЕХ-оос ирсэн зөвлөмж, аргачлалын дагуу сумдын сонгуулийн хороонд 47.6 сая төгрөгийг хуваарилсан байна.

2.2 Сумдын сонгуулийн хороо нь аймгийн Сонгуулийн хорооноос өгсөн аргачлал, зөвлөмжийн дагуу зардлыг санхүүжүүлж авлага, өр төлбөр үүсгээгүйгээр ажиллажээ.

Хүснэгт №1: Сумдын сонгуулийн хороодод олгосон санхүүжилт

Д/д	Сонгуулийн хорооны нэрс	Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Зөрүү
1	Дарви сумын сонгуулийн хороо	15.7	15.7	0
2	Манхан сумын сонгуулийн хороо	16.7	16.7	0
3	Мянгад сумын сонгуулийн хороо	15.2	15.2	0
Нийт дүн		47.6	47.6	0

2.3 Аймгийн сонгуулийн хороо нь 34.6 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлж 0.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

2.4 Саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх зардлыг 0.1 сая төгрөгийн хэмнэлт бий болсон байна.

2.5 УБЕГ-аас аймгийн УБХ-т 4.6 сая төгрөгийн зардлыг хуваарилж зарцуулан баталсан зардалд томилолтын зардал ороогүй тул хэмнэгдсэн зардлаас томилолтын зардлыг санхүүжүүлсэн байна.

График 1: УБХ-ийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл



Сонгуулийн хороод нь зардлын гүйцэтгэлийг аргачлалын дагуу тайлагнажээ

2.6 СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжийн 3 дугаар хавсралтаар сумдын сонгуулийн хороод төсвийн гүйцэтгэлийн тайланг гарган ирүүлж аймгийн сонгуулийн хороо нь нэгтгэн тайлагнасан байна.

Аймгийн сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлийг харуулбал:

Хүснэгт №2 Аймгийн сонгуулийн хорооны нэгтгэсэн тайлан

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Үлдэгдэл
1	Маягт хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	0.2	0.2	-
2	Сургалтын зардал	1.4	1.4	-
3	Бичиг хэргийн	1.2	1.2	-

4	Шуудан холбоо	1.6	1.6	-
5	Унааны зардал	4.1	4.1	-
6	Санал авах байр бэлтгэх	0.9	0.9	-
7	Сурталчилгааны зардал	2.1	2.1	-
8	Саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх зардал	12.9	12.8	0.1
9	МТБагийн гишүүний холбоо, унааны зардал	0.8	0.8	-
10	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх	0.4	0.4	-
11	Сонгуулийн хороодын урамшуулал, хоолны зардал	40.4	40.4	-
12	МТБагийн гишүүдийн урамшуулал, хоолны зардал	7.6	7.6	-
13	Томилолтын зардал	6.1	6.1	-
14	Шуурхай багийн зардал	2.6	2.6	-
	НИЙТ ДҮН	82.2	82.1	0

Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороодын хөрөнгийн зарцуулалтад хяналт тавин ажиллажээ

2.7 Аймгийн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд Ховд аймгийн 3 сумдаар ажиллаж сонгууль зохион байгуулахтай холбоотой хөрөнгийн зарцуулалт болон санал авах байранд ажиллах сертификат авсан төрийн жинхэнэ албан хаагчдыг хамарсан сургалт, арга зүйн зөвлөмж, зөвлөгөөг өгөн ажилласан байна.

2.8 Аймгийн сонгуулийн хороо нь 3 баг болж 3 сумдын 3 хэсгийн хороодод очиж хяналт шалгалтыг хийж ажиллажээ. Тус шалгалтаар жолоочийн тооцоо бодуулаагүй, санал авах байрны тохижилт дутуу хийгдсэн, хэсгийн хорооны гишүүд хороон дээрээ байгаагүй зэрэг дутагдал илэрснийг газар дээр нь засаж залруулан ажиллажээ.

2.9 Аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч нь сумдын сонгуулийн хорооны тайланг хүлээн авахдаа зөрүүтэй илэрхийлсэн алдааг хянаж залруулан авч дүнг үнэн зөв нэгтгэн гаргасан байна.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

✚ Сумдын ИТХ-ын нөхөн сонгуульд улсын төсвөөс олгох санхүүжилтийг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж хуваарилжээ.

✚ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул зөвлөмж өгөгдөөгүй болно.

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР